

НОТАРИАТЧИЙН МЭРГЭШЛИЙН ШАЛГАЛТАД БҮРТГҮҮЛЭХЭД ШААРДАГДАХ БИЧИГ БАРИМТЫН ЖАГСААЛТ

Нотариатчийн мэргэшлийн шалгалтад оролцох хүсэлтэй хуульчдыг 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 12 цаг 00 минутаас 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 17 цаг 00 минут хүртэл <http://burtgel.mojha.gov.mn/> хаягаар цахимаар бүртгэнэ.

Шалгалтад бүртгүүлэхэд дараах баримт бичгийг (PDF хэлбэрээр хавсаргах) бүрдүүлсэн байна. Үүнд:

- Нотариатчийн мэргэшлийн шалгалтад оролцохыг хүссэн өргөдөл /Хууль зүйн сайдын 2016 оны А/06 тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан өргөдлийн маягтын дагуу/
- Иргэний үнэмлэх;
- Эрх зүйн бакалаврын диплом
- Хуульчийн гэрчилгээ;
- Цээж зураг (сүүлийн нэг сарын дотор авахуулсан, албан хувцаслалттай /дүрэмт хувцастай байж болохгүй/, 3х4 хэмжээтэй);
- Оршин суугаа хаягийн лавлагаа (ТҮЦ машин, e-mongolia);
- Сэтгэцийн эрүүл мэндийн үзлэгийн тодорхойлолт; (Улаанбаатар хотоос оролцогч СЭМҮТ, орон нутгаас оролцогч аймгийн нэгдсэн эмнэлгээс авна.)
- Төлбөр тушаасан баримт.

Бүртгэлийн хураамж 100,000 /нэг зуун мянга/ төгрөгийг “Хаан банкны 5304190455 тоот П.Бумжаа” дансанд тушаана. /Гүйлгээний утга хэсэгт овог, нэрээ заавал бичнэ./

Шалгалтыг 2022 оны 06 дугаар сарын 13-ны өдрөөс 2022 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн хооронд Дотоод хэргийн их сургуулийн байранд зохион байгуулна.

АНХААРУУЛГА

- Бүртгэлийн хугацаанд баримтыг дутуу бүрдүүлсэн, хугацаа хоцорсон тохиолдолд Нотариатчийн мэргэшлийн хороо материалыг нөхөж авахгүй бөгөөд программд бүртгэл хийгдэх боломжгүй.
- Нотариатчийн сонгон шалгаруулалтын системд өөрийн зураг болон мэдээллийг бүрэн гүйцэд оруулна.

Шалгалттай холбоотой мэдээллийг 51–263502 утсаар лавлана уу.

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ
НОТАРИАТЧИЙН МЭРГЭШЛИЙН ХОРОО**